

## 2001 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

### *Ш.Догмийчойдон\**

- 01.01-05 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Бүгд Найрамдах Энэтхэг Улсад төрийн айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Багабанди БНЭУ-ын Ерөнхийлөгч К.Н.Нараянантай уулзаж, хоёр талын харилцааны болон бүс нутгийн, олон улсын холбогдолтой харилцан сонирхсон асуудлаар ярилцав. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНЭУ-ын Ерөнхий сайд А.Б.Важлаитай албан ёсны хэлэлцээ хийж, хоёр талын харилцааны цаашдын хөгжил, гадаад орнуудтай харилцаж буй байдал, олон улсын терроризм, НҮБ-ыг шинэчлэх болон олон улсын бусад асуудлаар санал болгоо солилцов. Хоёр тал “Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Гэрээ”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ”, “Иргэний болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ”, “Батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагааны тухай Хэлэлцээр”, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, хамгаалах тухай Хэлэлцээр”, “Мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцох санамж бичиг”-т тус тус гарын үсэг зурав.
- 01.05-07 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Цог Жавхланта Ван Бирендра Бир Бикрам Шах Девийн албан ёсны урилгаар Балбын Вант Улсад төрийн айлчлал хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Балбын Вант Улсын Ерөнхий сайд Гирижа Прасад Койрала, албаны бусад хүмүүс оролцсон албан ёсны хэлэлцээ хийж хоёр орны хоорондын эдийн засаг, худалдааны харилцааны өнөөгийн байдлыг авч үзээд эдгээр салбарт байгаа нөөц боломжоо цаашид ашиглахаар тохиролцов.
- 01.22 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Европын Холбоонд ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Ерөнхий

\* Ш.Догмийчойдон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

сайд Н.Энхбаяр Европын Зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга, Хамтын гадаад бодлого, аюулгүй байдлын асуудал эрхэлсэн дээд төлөөлөгч Хавьер Солана, Европын Парламентын дэд дарга Йан Кеес Виебенга, Европын Комиссын гадаад харилцааны асуудал эрхэлсэн комиссар Кристофер Паттен, Умард Атлантын Гэрээний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Лорд Джорж Робертсон нартай уулзаж Монгол Улс Европын Холбоотой 1989 онд дипломат харилцаа тогтоосноос хойш харилцаа, хамтын ажиллагаа тогтвортой, үр дүнтэй өрнөж байгаад сэтгэл ханамжтай байдгаа цохон тэмдэглээд, улс төрийн яриа хэлэлцээг тогтмолжуулах үүднээс Европын Комисс, Европын Зөвлөлийн төлөөлөгчдийг Монголд хүлээн авах, Европын Холбооны байнгын төлөөлөгчийн газрыг Улаанбаатарт нээх хүсэлтэй байгаагаа илэрхийлэв.

- 01.23 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Люксембургийн Их вант Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын явцад хоёр талын төлөөлөгчид хэлэлцээ хийж Монгол-Люксембургийн харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх асуудлаар санал солилцов. Мөн Монголд “Зүрхний оношлогооны төв байгуулах тухай” төслийн ерөнхий баримт бичигт Ерөнхий сайд Н.Энхбаяр, Люксембургийн Ерөнхий сайд Жан Клод Юнкер нар гарын үсэг зурав.
- 01.25-30 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт”-ын Ерөнхийлөгч профессор Клаус Швабын урилгаар Швейцарын Давос хотноо уг чуулга уулзалтанд оролцов. Уг чуулга уулзалтын үеэр Ерөнхий сайд Н.Энхбаяр Франц, Швейцарын Веритас группын төлөөлөгчид, уг чуулга уулзалтын гүйцэтгэх захирал Фредерик Сикре болон Дэлхийн худалдааны байгууллагын Ерөнхий захирал Майк Муур зэрэг албаны хүмүүстэй уулзаж өөрийн орны худалдаа, хөрөнгө оруулалтын нөхцөл байдал, Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлого, зорилтоо танилцуулж даяарчлах үйл явцад улс орнуудын худалдаа, эдийн засгийн харилцааны хөгжлийн хандлага, түүнд жижиг орнуудын эзлэх байр суурийн талаар санал солилцов.
- 02.12-15 БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүний урилгаар Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди БНСУ-д төрийн

айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Багабанди БНСУ-ын Ерөнхийлөгч Ким Дэ Жүнтэй ганцаарчлан уулзсаны сацуу өргөтгөсөн хэлэлцээ хийсэн бөгөөд мөн БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга Ли Ман Сөб, Ерөнхий сайд Ли Хан Дон болон албан бусад хүмүүстэй уулзав. Айлчлалын үеэр “Залуучуудын байгууллагын салбарт хамтран ажиллах тухай Тохиролцоо”, “Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны тухай Протокол” зэрэг зарим баримт бичигт тус тус гарын үсэг зурав. Мөн хоёр тал соёл боловсрол, эдийн засаг, байгаль орчин зэрэг салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх талаар тохиролцов. Айлчлалын дүнд “Монгол Улс, БНСУ-ын хамтарсан хэвлэлийн мэдэгдэл” гаргав.

02.13-18 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр Япон Улсын Засгийн газрын урилгаар тус улсад айлчлав. Ерөнхий сайд Н.Энхбаяр Японы Цог жавхланг эзэн хаан Хирохитод бараалхаж, Ерөнхий сайд Ё.Мори, Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Ю.Иноүэ, Гадаад хэргийн сайд Ё.Кооно, ЛАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Кога, ЯСДН-ын дарга Т.Дой, Японы Олон улсын Хамтын ажиллагааны Банк (JBIC)-ны ерөнхийлөгч Х.Ясуда, Японы Олон улсын Хамтын ажиллагааны Агентлаг (JICA)-ийн ерөнхийлөгч К.Сайто, Японы Гадаад Худалдааг Дэмжих Байгууллага(JETRO)-ЫН ерөнхийлөгч Н.Хатакэяма, Япон сан (Japan Foundation)-гийн ерөнхийлөгч Х.Фүжий болон албаны бусад хүмүүстэй уулзаж ярилцав. Хоёр тал хоорондын улс төрийн харилцааг улам хөгжүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, дэд бүтцийг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрийг сэргээх, мэдээллийн технологи, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, газар тариалан, мал аж ахуйг байгалийн бэрхшээлээс гаргаж, зудаас сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, боловсон хүчин бэлтгэх зэрэг асуудлаар санал солилцож, хамтран ажиллахаар тохиролцов. Айлчлалын үеэр “Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулав. Энэхүү айлчлалын дүнд Хамтарсан хэвлэлийн мэдээ гаргав.

02.15-17 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Бүгд Найрамдах Сингапур Улсын Ерөнхийлөгч С.Р.Натаны урилгаар тус

улсад төрийн айлчлал хийв. Ерөнхийлөгч Н.Багабанди Сингапурын Ерөнхийлөгч С.Р.Натан, Ерөнхий сайд Го Чок Тон нартай албан ёсоор уулзаж ярилцав. Уг уулзалтын үеэр хоёр тал Монгол, Сингапурын харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх асуудлаар санал солилцов. Айлчлалын үеэр хоёр тал жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны хооронд хамтран ажиллах асуудлаар харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зурав.

- 02.19-22 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Арабын Нэгдсэн Эмирт улсад албан ёсоор айлчлав. Ерөнхийлөгч Н.Багабанди АНЭУ-ын Ерөнхий Сайдын орлогч Шейх Султаан бин Заид Аль-Нахъяантай албан ёсны хэлэлцээ хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, Абу Дабигийн хөгжлийн Сангийн хоорондын хамтын ажиллагааны тухай Санамж бичиг, Хөрөнгө оруулалтыг хамгаалах, хөхиүлэн дэмжих тухай Хэлэлцээр, Давхар татвараас чөлөөлөх тухай Хэлэлцээр зэрэг албан бичигт тус тус гарын үсэг зурав.
- 03.06 ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Ерөнхийлөгч Л.В.Потапов Монгол Улсын **Засгийн газрын** урилгаар тус улсад айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар БН Буриад Улсын Ерөнхийлөгч Л.В.Потаповыг тус тус хүлээн авч уулзсан бөгөөд БН Буриад Улсын Ерөнхийлөгч Л.В.Потапов, Монгол Улсын Дэд бүтцийн сайд Б.Жигжид нар хэлэлцээ хийв.
- 03.15 Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Укриан Улсаас Монгол Улсад суух Элчин сайд И.А.Литвин, Холбооны Нигери Улсаас Монгол Улсад суух Элчин сайд Олагунжу Адесакин нар тус тус Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 03.29- УИХ-ын Дэд дарга Ж.Бямбадорж тэргүүтэй төлөөлөгчид  
04.07 БНКУ-ын нийслэл Гавана хотод Олон улсын парламентын холбооны ээлжит 105-р бага хуралд оролцов.
- 04.02-04 Монгол, Польшийн Гадаад Хэргийн Яамдын зөвлөлдөх уулзалт Улаанбаатар хотноо болж Польшийн Гадаад Хэргийн Яамны департаментын захирал А.Кремер тэргүүтэй

төлөөлөгчид оролцов. Зөвлөлдөх уулзалтаар хоёр улсын консулын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлын талаар дүгнэн ярилцаж, Монгол Полшийн Засгийн газар хоорондын иргэд харилцан визгүй зорчих тухай 1975 оны хэлэлцээрээс гарахаар БНПУ-ын Засгийн газар шийдвэрлэсний дагуу 2001 оны 5 дугаар сарын 5-наас эхлэн харилцан визтэй зорчих журамд шилжиж байгаатай холбогдуулан цаашид авах арга хэмжээний талаар зөвлөлдөв. Уулзалтын үеэр Полшийн тал 2001 оны 5 дугаар сард Улаанбаатарт ЭСЯ-аа сэргээн нээх тухайгаа нотлов.

- 04.04 Монгол Улс, Тонгагийн Вант Улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай Протоколд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Ж.Энхсайхан, Тонгагийн Вант Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч С.Т.Т.Тупоу нар Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн Газарт гарын үсэг зурав.
- 04.16-17 Канад Улсын Гадаад хэрэг, Олон улсын худалдааны департаментын Ази, Номхон далайн асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн дарга Рей Пагтахан Монголд Улсад айлчилав. Айлчлалын үеэр тэрбээр Ерөнхий сайд Н.Энхбаяр, Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун болон албаны бусад хүмүүстэй уулзаж хэлэлцээ хийв.
- 04.20 БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн нарийн бичгийн дарга Ван Юйши тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчлав.
- 04.22 Монгол Улсын Их хурлын дарга Л.Энэбиш тэргүүтэй төлөөлөгчид Мексикийн Нэгдсэн Улсын Үндэсний Конгрессийн урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Үндэсний Конгрессийн дарга бөгөөд Депутатуудын танхимын Удирдах Зөвлөлийн дарга Рикардо Гарсия Сервантес, Мексикийн Гадаад хэргийн сайдын үүрэг гүйцэтгэгч, дэд сайд Мигель Марин Босч, Үндэсний Конгрессийн Сенатын танхимын удирдах зөвлөлийн дарга Энрике Жексон нартай тус тус уулзав.

- 04.24-27 Монгол Улс, Бүгд Найрамдах Унгар Улсын Гадаад Хэргийн Яамдын ээлжит зөвлөлдөөн Улаанбаатар хотноо болов. Уулзалт зөвлөлдөөнөөр Монгол Унгарын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэхтэй холбогдсон өргөн хүрээтэй асуудлаар харилцан мэдээлэл хийж, санал солилцож, соёл шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагааг идэвхжүүлэх, байгаль орчныг хамгаалах, геологи, усны судалгаа, хайгуулын салбарт хамтын ажиллагааг сэргээн хэрэгжүүлэх, аялал жуулчлал болон хоёр талын иргэд харилцан зорчих нөхцлийн тухай зэрэг асуудлаар санал солилцож тохиролцов.
- 04.25 Монгол Улсын Их хурлын дарга Л.Энэбиш тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Куба Улсын Үндэсний Ассамблейн урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийв.
- 05.02 Францын Гадаад хэргийн Яамны Ази, Номхон далайн газрын Ерөнхий захирал Доминик Жерар тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлав. Айлчлалын үеэр Монгол-Францын соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Хамтарсан комиссын 13-р хуралдаан болж хоёр талын ашиг сонирхолд нийцсэн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх үүднээс соёл, боловсрол, шинжлэх ухаан, техникийн салбарт харилцаагаа хөгжүүлэн бэхжүүлэхээр тохиролцов.
- 05.10-12 ОХУ-ын Кемеров мужийн захирагч А.Г.Тулеев Монгол улсын Засгийн газрын урилгаар манай улсад албан ёсны айлчлал хийв. Тэрбээр айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид бараалхсан бөгөөд Монгол Улсын Дэд бүтцийн сайд, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн дарга Б.Жигжиттэй уулзав.
- 05.12 Бүгд Найрамдах Унгар Улсын Үндэсний Ассамблейн дэд дарга хатагтай Сили Каталин тэргүүтэй төлөөлөгчид манай

улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж хатагтай Сили Каталинийг хүлээн авч уулзаж хоёр орны харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

- 05.14 ОХУ-ын Иргэний хамгаалалт, онц байдал, байгалийн гамшгийн хор хөнөөлийг арилгах асуудал эрхэлсэн сайд С.К.Шойгу манай улсад айлчлав. Сайд С.К.Шойгуг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар тус тус хүлээн авч уулзав. Айлчлалын үеэр Батлан Хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, ОХУ-ын Иргэний хамгаалалт, онц байдал, байгалийн гамшгийн хор хөнөөлийг арилгах асуудал эрхэлсэн сайд С.К.Шойгу нар Үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах салбарт хамтран ажиллах Монгол, Оросын хамтарсан комиссын тавдугаар хуралдааны протоколд гарын үсэг зурав.
- 05.15 ОХУ-ын Холбооны хурлын төрийн Дум дахь Монгол-Оросын бүлгийн дарга С.П.Будажанов тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.
- 05.15-16 Монголд Хандивлагчдын зөвлөлдөх уулзалт Парис хотноо болов. Уг зөвлөлдөх уулзалтад Австрали, Канад, БНХАУ, Чех, Франц, Герман, Энэтхэг, Япон, БНСУ, Кувейт, Люксембург, Нидерланд, ОХУ, Швед, Швейцари, Турк, Их Британи, Умар Ирландын Нэгдсэн вант улс, АНУ зэрэг 18 орон, олон улсын 14 байгууллага оролцов.
- 05.21 Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун НҮБ-ийн Вена дахь төвийн Ерөнхий захирал бөгөөд Мансууруулах бодист хяналт тавих, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын төвийн Гүйцэтгэх захирал Пино Арлаккитай уулзав. Уулзалтын үеэр мансууруулах бодист хяналт тавих, гэмт хэргээс урдчилан сэргийлэх НҮБ-ын төв, Монгол Улстай хамтран ажиллах, техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх замаар хамтран ажиллах зэрэг асуудлаар санал солилцож, хамтран ажиллахаар тохиролцов.



- 05.22 Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Австрийн Гадаад Хэргийн Яамны Ерөнхий нарийн бичгийн дарга Алберт Рохантай уулзаж, Монгол-Австрийн харилцааны болон бусад сонирхсон асуудлаар санал солилцож ярилцав. Хоёр сайд Монгол Улс, Австри Улсын хооронд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах хэлэлцээрт гарын үсэг зурав.
- 05.23 НҮБ-ын Женевийн төвд айлчилж байгаа Монгол Улсын Гадаад Хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Зэвсэг хураах бүгд хуралдаанд оролцож олон улсын аюулгүй байдал, зэвсэг хураах асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэлэв. Айлчлалын үеэр НҮБ-ын Хүний эрхийн дээд Комиссар хатагтай М.Робинсонтой уулзаж, өнгөрсөн оны сүүлээр байгуулагдсан Хүний эрхийн үндэсний комиссыг бэхжүүлэх, хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, урьдчилан хорих байгууллагуудын нөхцлийг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлэх талаар санал солилцож энэ бүгдийг тусгасан Хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав.
- 05.28-30 Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Бүгд Найрамдах Беларусь Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр тал Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр, Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ноогдуулгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрт гарын үсэг зурав.
- 05.30 Бүгд Найрамдах Польш Улсын Элчин сайд Кшиштоф Дэнбничи Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ барив.
- 06.14 Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Элчин сайд Бернард Антон Бандара Гунетиллеке, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Элчин сайд Хюмаюн А.Камал нар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итгэмжлэх жуух бичгээ тус тус барив.



- 06.18-19 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхий сайд Ли Хан Донг манай улсад албан ёсны айлчлал хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дарга Л.Энэбиш нар БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хан Донгийг хүлээн авч уулзсан бөгөөд Ерөнхий сайд Н.Энхбаяр БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хан Донгтой албан ёсны хэлэлцээ хийв. Хоёр тал Жижиг, дунд үйлдвэрийн салбарт хамтран ажиллах яамд хоорондын хэлэлцээр, Монголын Цахилгаан холбоо болон Солонгосын Корё Телеком компанийн хооронд хэрэгжүүлэх арилжааны гэрээнд тус тус гарын үсэг зурав.
- 06.19-20 Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын хоёрдугаар хуралдаан Улаанбаатар хотноо болов. Энэхүү хуралдааны төгсгөлийн баримт бичиг-Протокол гаргаж Монголын төлөөлөгчдийн тэргүүн Үйлдвэр худалдааны дэд сайд, дэд комиссын Монголын хэсгийн дарга О.Эрдэнээ, Оросын төлөөлөгчдийн тэргүүн ОХУ-ын Холбоо, үндэстнүүд, иргэдийн шилжилт хөдөлгөөний бодлогын яамны нэгдүгээр орлогч сайд, дэд комиссын Оросын хэсгийн дарга В.А.Кирпичников нар гарын үсэг зурав.
- 06.21 Бүгд Найрамдах Филиппин Улсын Элчин сайд Хосе Эл Вилла Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Итэмжлэх жуух бичгээ барив.
- 06-р сар Монгол Улс, БНХАУ-ын Гадаад хэргийн Яамдын зөвлөлдөх уулзалт Бээжин хотноо болов. Энэхүү уулзалтад Монгол Улсын Гадаад хэргийн дэд сайд С.Батболд, БНХАУ-ын Гадаад хэргийн яамны орлогч сайд Ван И нар хоёр талын төлөөлөгчдийг тэргүүлэн оролцож Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар хэлэлцээ хийж, санал солилцов.
- 07.02-06 “Эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Комиссын 7 дугаар хуралдаан Бээжин хотноо болов. Комиссын нэгдсэн хуралдааны дараа “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны

хэлэлцээр”-т Монгол Улсын Дэд бүтцийн сайд, Комиссын Монголын хэсгийн дарга Б.Жигжид, БНХАУ-ын Гадаад худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагааны яамны дэд сайд, Комиссын Хятадын хэсгийн дарга Ан Мин нар гарын үсэг зурав.

- 07.03 БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Тан Зясюань Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дэд дарга Ж.Бямбадорж, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр нар БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Тан Зясюанийг хүлээн авч уулзсан бөгөөд Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Тан Зясюань нар албан ёсны хэлэлцээ хийв.
- 07.04 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандил Бүгд Найрамдах Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Константин Фотилас итгэмжлэх жуух бичгээ барив.
- 07.26-28 Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун БНСВУ-д албан ёсоор айлчлав. Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, БНСВУ-ын Соёл, мэдээллийн сайд Фам Куанг Нгхи нар “Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол, Вьетнамын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурав.
- 07.27 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, УИХ-ын дарга Л.Энэбиш, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар Бүгд Найрамдах Турк Улсын Төрийн сайд Абдулхалук Мэхмэт Чай тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.
- 07.29-31 Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Гадаад хэргийн сайд Сомсават Ленгсавадын урилгаар БНАЛАУ-д албан ёсоор айлчлав. Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулууныг БНАЛАУ-ын Дэд Ерөнхийлөгч Чүммали Саяасон, Ерөнхий сайд Бүнниан Ворачит нар хүлээн авч уулзсан бөгөөд Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун БНАЛАУ-ын Гадаад хэргийн сайд Сомсават Ленгсавадтай

албан ёсны хэлэлцээ хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Гадаад хэргийн яам, БНАЛАУ-ын Гадаад хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай Протоколд хоёр улсын Гадаад хэргийн сайд нар гарын үсэг зурав.

07-р сард Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Ханой хотноо АСЕАН-ы бүс нутгийн чуулгын /АРФ/ Сайд нарын ээлжит 8 дугаар уулзалтад оролцов. Энэ удаагийн уулзалтад Ази, Номхон далайн бүс нутгийн 23 улсын Гадаад хэргийн сайд нар болон Европын Холбооны төлөөлөгчид ирж оролцсон бөгөөд уулзалтаар Урьдчилан сэргийлэх дипломат үйл ажиллагааны үзэл баримтлал ба зарчим, бүс нутгийн шинжээчид нэрт эрдэмтний жагсаалт бий болгох, Чуулгын даргын үүрэг ролийг нэмэгдүүлэх тухай зэрэг баримт бичгийг зөвшилцөн баталж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлов.

08.15-16 Монгол Улсын Өргөмжит консулуудын ээлжит Гуравдугаар зөвлөлдөх уулзалт болов. Энэхүү уулзалтад Монгол Улсыг гадаадад төлөөлөн ажиллаж байгаа 39 Өргөмжит консулуудаас 24 Өргөмжит консул оролцов.

09.03 Монгол Улс Нэгдсэн Үндэстэний Байгууллагад элссэний 40 жилийн ойн арга хэмжээнд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын бие төлөөлөгчөөр оролцож буй Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Женев дэх НҮБ-ын салбарын Ерөнхий захирал В.Петровскийг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар хүлээн авч уулзав.

09.06 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Шинэ Зеланд Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жон Валтер Макиннон итгэмжлэх жуух бичгээ барив.

09.09-11 Дэд бүтцийн сайд Б.Жигжидийн урилгаар БНЭУ-ын Мэдээллийн технологийн сайд П.Махажан манай улсад айлчлал хийв. Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Ерөнхий сайд Н.Энхбаяр нар БНЭУ-ын Мэдээлэл технологийн сайд П.Махажаныг тус тус хүлээн авч уулзсан бөгөөд Монгол-Энэтхэгийн мэдээлэл холбооны

- салбарт хамтран ажиллах гэрээнд Монгол Улсын Дэд бүтцийн сайд Б.Жигжид, БНЭУ-ын Мэдээлэл технологийн сайд П.Махажан нар гарын үсэг зурав.
- 09.26 Монгол улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Тайландын Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дон Ргамувиной итгэмжлэх жуух бичгээ барив.
- 10.21 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн захирал Хафиз Пашаг хүлээн авч уулзав.
- 10.24-11.06 Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын улсын хилийн шугамыг шалгах Хамтарсан комиссын хуралдаан Улаанбаатар хотноо болов. Хуралдааны үеэр талууд Монгол, Хятадын улсын хилийн шугамыг хоёр дахь удаа хамтран шалгах ажлын зарчим, үүрэг, баримт бичиг болон бусад холбогдох асуудлаар хэлэлцээ хийж тохиролцоонд хүрэв.
- 10.30-11.4 Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун ОХУ-ын Гадаад хэргийн сайд И.С.Ивановтой албан ёсны хэлэлцээ хийв. Мөн айлчлалын үеэр Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 80 жилийн ойн арга хэмжээнд оролцов.
- 11.04-21 Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид АНУ-д албан ёсны айлчлал хийв. Айлчлалын хугацаанд Ерөнхий сайд Н.Энхбаяр АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш, Төрийн нарийн бичгийн дарга Колин Пауэлл, Конгрессын гишүүн Жим Маклермот, Конгрессын төлөөлөгчдийн танхимын Төсвийн байнгын хорооны дарга Жей Инзли нартай тус тус уулзаж хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, АНУ-д Монголоос суралцах оюутны тоог нэмэгдүүлэх, монгол иргэдийг АНУ-д хөдөлмөр эрхлүүлэх, олон улсын байдал, олон улсын терроризмын эсрэг тэмцэх зэрэг олон асуудлаар харилцан ярилцаж санал солилцов. Айлчлалын үеэр Ерөнхий сайд

Н.Энхбаяр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 56-р чуулганд оролцож үг хэлсэн бөгөөд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан, БНСУ-ын Ерөнхий сайд Ли Хан Донг, БНСУ-ын Гадаад хэргийн сайд Хан Сеунг-Суу, Румын улсын ерөнхийлөгч Ион Илиреску зэрэг хүмүүстэй тус тус уулзаж ярилцав.

- 11.05-06 Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн хуралдаан Эрхүү хотноо болов. Хуралдаанаар Сибирийн холбооны тойрог болон Монголын хоорондын харилцаа холбоог өргөтгөх зорилгоор байнгын ажиллагаатай комисс байгуулах шийдвэр гаргав. Хуралдааны явцад Сибирийн холбооны тойрог, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг хоорондын хамтын ажиллагааны тухай Меморандум, монгол Улсын Сэлэнгэ аймаг болон ОХУ-ын Усть-Ордын Буриадын автономит тойргийн хоорондын хамтын ажиллагааны Хэлэлцээрт гарын үсэг зурав.
- 11.05 Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Ерөнхий захирал Хуан Сомавиатай Женев хотноо уулзав. Уулзалтын үеэр Монгол Улс, ОУХБ-ын хооронд 1995 онд тохиролцсон хамтын ажиллагааны зорилтод хөтөлбөрийг шинэчлэх, энэ зорилгоор ОУХБ-ын мэргэжилтэний хэсгийг Монголд явуулж ажиллуулах зэрэг асуудлыг тохиров.
- 11.06 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Нидерландын Вант Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Филлин Де Хеер итгэмжлэх жуух бичгээ барив.
- 11.19-21 Монгол Улсын Засгийн газрын урилгаар Дэлхийн оюуны өмчийн байгууллага (ДООБ)-ын ерөнхий захирал, доктор Камил Идрис манай оронд айлчлав.
- 11.29 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид БНХАУ-ын ХАЧА-ийн ар талыг удирдах ерөнхий газрын улс төрийн комиссар, хурандаа генерал Жоу Күнз Ян тэргүүтэй төлөөлөгчид бараалхаж хоёр орны хоорондын Батлан

хамгаалах, Зэвсэгт хүчний салбарын хамтын ажиллагаа, хэтийн төлвийн талаар харилцан ярилцаж санал солилцов.

11-р сар Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ЭСКАП)-ын гишүүн, Ази, Номхон далайн орнуудын дэд бүтцийн сайд нарын бага хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн сайд Б.Жигжид оролцов. Хурлын үеэр Дэд бүтцийн сайд Б.Жигжид БНСУ-ын Мэдээлэл, холбооны сайд Ян Сөн Тэк, Соёл, аялал жуулчлалын сайд Нам Күн Жин, Барилга тээврийн сайд Лим Ин Тэк, Үйлдвэр, худалдаа, нөөцийн дэд сайд Ким Дон Вон зэрэг хүмүүстэй уулзаж мэдээллийн технологийн салбарт хамтран ажиллах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, Оросын нутгаас нефть, хийн хоолойг Монголын нутгаар дамжуулан тавих, Монгол орны эрчим хүчний хангамжийг сайжруулах зэрэг хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлаар санал солилцов.

12.07 Монгол Улс Элчин сайдын яамаа Канадын нийслэл Оттава хотод нээв.

12.13-19 Монгол Улс, ОХУ-ын хоорондын улсын хилийг шалгах Монгол-Оросын хамтарсан комиссын төлөөлөгчдийн дарга нарын ажлын уулзалт Улаанбаатар хотноо болов. Уулзалтаар улсын хилийг 2001 онд хамтран шалгасан дүнгийн үндсэн баримт бичиг болох “Монгол Улс, ОХУ-ын хоорондын улсын хилийн шугамын Тодорхойлолт-Протокол”-д Монгол-Оросын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн дарга Л.Мундагбаатар, Оросын хэсгийн дарга В.Н.Щетинин нар гарын үсэг зурав.

12.13-14 ОХУ-ын Гадаад хэргийн яамны Азийн газрын дарга Е.В.Афанасьев манай улсад ажлын айлчлал хийж, Монгол Улсын Гадаад хэргийн яамны холбогдох газруудтай зөвлөлдөх уулзалт хийв.

12.14 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандид Монгол Улсаас Ливан улсад суух Өргөмжит консул Жорж ил-Хашим итгэмжлэлээ гардуулав.